



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 209

Улаанбаатар хот

Г “Аудитын чанарын хяналтын 7
түр журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Аудитын чанарын хяналтын түр журам” - ыг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрдлийн үнэлгээ, судалгаа, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний газар /даргын үүрэг түр орлон гүйцэтгэгч П.Наранцэцэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-д тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

АУДИТЫН ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ТҮР ЖУРАМ

Нэг . Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь аудитын компаний үйл ажиллагаа Аудитын олон улсын стандарт (цаашид АОУС гэх), Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (цаашид СТОУС гэх), Чанарын хяналтын олон улсын стандарт (цаашид ЧХОУС гэх) - ын зарчимд нийцэж буй эсэхийг тодорхойлох, аудитын чанарыг сайжруулах талаар зөвлөмж дүгнэлт өгөх, аудитын горим, чанарын хяналтын бодлого, горимын хэрэгжилтийг үнэлж дүгнэхэд оршино.

1.2. Аудитын чанарын хяналт нь аудитын дүгнэлтийг батлах бус, аудитын байгууллагын үйл ажиллагаа холбогдох хууль, стандартын дагуу явагдаж байгаа эсэхийг тодорхойлох, зөвлөгөө өгөх замаар аудитын гүйцэтгэлийн чанарыг сайжруулж, зохицуулалтын хүрээний байгууллагуудад НББОУС, СТОУССтандартуудыг бүрэн нэвтрүүлж, санхүүгийн тайлагналын чанарыг дээшлүүлж, олон нийтийг үнэн зөв мэдээлэлээр хангахад чиглэгдэнэ.

1.3. Аудитын компаний мэдээллийг 1 дүгээр хавсралтаар, аудитын гүйцэтгэлийн чанарын хяналтыг 2 дугаар хавсралтаар, АОУССтандартын хэрэгжилтийг 3 дугаар хавсралтаар тус тус шалгана.

1.4. Энэ журмыг аудитын байгууллагад чанарын хяналт хэрэгжүүлж буй холбогдох байгууллагын ажилтнууд ашиглана.

Хоёр. Аудитын чанарын хяналтын зохион байгуулалт, багийн гишүүдийн үүрэг

2.1. Санхүүгийн тайлагнал, аудит, үнэлгээний чанарын хяналтын газар (цаашид СТАҮЧХГ гэх) холбогдох газрын мэргэжилтэнг оролцуулан 3 хүртэл хүний бүрэлдэхүүнтэйгээр аудитын чанарын хяналтын үйл ажиллагааг зохион байгуулна.

2.2. Аудитын чанарын хяналтын удирдамж төлөвлөгөөг хорооны дарга батална.

2.3. Чанарын хяналтыг зохицуулалтын хүрээний байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийсний дараа 2-р улирлаас эхлэн жилд 1 удаа хийнэ.

2.4. Хорооноос батлагдсан хуваарь, хяналтын ажлын төлөвлөгөө, удирдамжийн дагуу аудитын чанарын хяналтыг гүйцэтгэнэ.

2.5. Чанарын хяналтын баг нь Аудитын тухай хууль, “Аудитын чанарын хяналтын журам “- ын дагуу үйл ажиллагаагаа зохион байгуулна.

2.6. Чанарын хяналтын багийн гишүүд шалгалтын явцад олж авсан мэдээллийн нууцыг хадгална.

2.7. Шалгагдсан аудитын компанийн үйл ажиллагааны талаар ажлын хэсэг шалгалтын тайлан бичнэ.

2.8. Шалгалтын тайланд аудитын компаниудын аудитын үйл ажиллагаа нь хууль, дүрэм журам, стандартын шаардлага хангаж байгаа эсэх, чанарын хяналтын баримтлах чиглэл, горимын хэрэгжилтийн талаар бичиж багийн гишүүд гарын үсэг зурна.

2.9. Чанарын хяналтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах хугацаатай албан шаардлага өгч, биелэлтийг шалгана.

2.10. Аудитын байгууллагын чанарын хяналтын дүгнэлт, ажлын баримтыг үдэж хувийн хэрэгт хавсаргана.

Гурав . Аудитын гүйцэтгэлийн чанарын хяналтын төрөл

3.1. Мөнгөн хөрөнгийн аудитын чанарын хяналт

3.1.1. Мөнгөн хөрөнгийн чанарын хяналтын горимоор мөнгөн хөрөнгө бодитоор байгаа эсэх, тухайн компани бүрэн эзэмшиж, үлдэгдэл нь үнэн зөв ангилагдсан эсэх, хүлээн авсан болон зарцуулсан мөнгөн хөрөнгийн тасалбар болголт зөв эсэхийг хянах,

3.1.2. Аудитын компанийн хийсэн мөнгөн хөрөнгийн аудитын хамрах хүрээ, горимуудын хэрэгжилтийг хүснэгт 1А (1-7)- оор бүрэн шалгаж тайлбар өгөх,

3.2. Авлагын дансны аудитын чанарын хяналт

3.2.1. Авлагын данс нь балансын өдрийн эцсийн өдрөөр бүх авлагыг багтаасан эсэх, эргэлзээтэй авлагын хасагдуулга зөв тооцогдсон эсэх, хөнгөлөлт тооцсон эсвэл хуваарилагдсан авлагын дансууд, гуравдагч талуудын авлага үнэн зөв тодруулагдсан эсэх, авлагын данс санхүүгийн тайланд зөв ангилагдсан эсэх, насжилтийг үнэн зөв тогтоосон эсэх, холбоотой талын авлага үнэн зөв тусгагдсан зэргийг хянах,

3.2.2. Аудитын компанийн хийсэн авлагын дансны аудитын хамрах хүрээ, горимуудын хэрэгжилтийг хүснэгт 1Б (1-10)- аар бүрэн шалгаж тайлбар өгөх,

3.3. Бараа материалын аудитын чанарын хяналт

3.3.1. Бараа материал нь биет байдлаар агуулахад хадгалагдаж байгаа эсэх, үлдэгдэл үнэн зөв бүртгэгдсэн эсэх, өртөг нь зах зээлийн үнийн аль бага үнээр үнэлэгдсэн эсэх, зөв ангилагдсан эсэхийг хянах,

3.3.2 Аудитын компанийн хийсэн бараа материалын аудитын хамрах хүрээ, горимуудын хэрэгжилтийг хүснэгт 1В (1-8)-аар бүрэн шалгаж тайлбар өгөх,

3.4. Хөрөнгө оруулалтын дансны аудитын чанарын хяналт

3.4.1. Хөрөнгө оруулалтын үлдэгдэл нь санхүүгийн тайланд бүрэн тусгагдсан эсэх, хөрөнгө оруулалтын ашиг алдагдал, үнэлгээний хасагдуулга, хөрөнгө оруулалт борлуулсны олз ба гарз зах зээлийн үнийн өөрчлөлт үнэн зөв бүртгэгдсэн эсэхийг шалгах,

3.4.2. Аудитын компанийн хийсэн хөрөнгө оруулалтын дансны аудитын хамрах хүрээ, горимуудын хэрэгжилтийг хүснэгт 1Г (1-9)-өөр бүрэн шалгаж тайлбар өгөх,

3.5. Үндсэн хөрөнгийн аудитын чанарын хяналт

3.5.1. Үндсэн хөрөнгө нь биет байдлаар агуулахад болон ашиглалтанд байгаа эсэх, үлдэгдэл үнэн зөв бүртгэгдсэн эсэх, өртөг нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчмын дагуу үнэлэгдсэн эсэх, зөв ангилагдсан эсэх, элэгдлийн зардлыг зөв тооцсон эсэхийг хянах,

3.5.2. Аудитын компанийн хийсэн үндсэн хөрөнгийн аудитын хамрах хүрээ, горимуудын хэрэгжилтийг хүснэгт 2 (1-10)-аар бүрэн шалгаж тайлбар өгөх,

3.6. Урт болон богино хугацаат өр төлбөрийн аудитын чанарын хяналт

3.6.1. Урт болон богино хугацаат өр төлбөр зөв ангилагдсан эсэх үлдэгдэл үнэн зөв тодорхойлогдсон эсэхийг хянах,

3.6.2. Аудитын компанийн хийсэн урт болон богино хугацаат өр төлбөрийн аудитын хамрах хүрээ, горимуудын хэрэгжилтийг хүснэгт 3А (1-11)-ээр бүрэн шалгаж тайлбар өгөх,

3.7. Татварын өр, хойшлогдсон татварын хөрөнгийн аудитын чанарын хяналт

3.7.1. Татварын тооцоолол үнэн зөв эсэх, татварын өр, хойшлогдсон татварын хөрөнгийн холбогдох дансдын бичилт зөв эсэхийг шалгах,

3.7.2. Аудитын компанийн хийсэн татварын өр хойшлогдсон татварын хөрөнгийн аудитын хамрах хүрээ, горимуудын хэрэгжилтийг хүснэгт 3Б (1-9)-өөр бүрэн шалгаж тайлбар өгөх,

3.8. Эзэмшигчийн өмчийн аудитын чанарын хяналт

3.8.1. Эзэмшигчийн өмчийн ажил гүйлгээ нэмэгдсэн капитал, хуваарилагдсан капитал, хувьцааны бүртгэл нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу бүртгэгдсэн эсэхийг шинжилж, данс бүртгэлд үнэн зөв бүртгэгдсэн эсэх, стандарт, чанарын хяналтын горим шаардлагыг хангасан эсэхийг шалгах,

3.8.2. Аудитын компанийн хийсэн эзэмшигчийн өмчийн аудитын горимуудын хамрах хүрээ, хэрэгжилтийг хүснэгт 4А (1-6)-аар бүрэн шалгаж тайлбар өгөх,

3.9. Ашиг алдагдлын дансны чанарын хяналт

3.9.1. Ашиг алдагдал үнэн зөв тодорхойлогдсон эсэх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу бүртгэгдсэн эсэхийг шинжилж, данс бүртгэлд үнэн зөв бүртгэгдсэн эсэх, стандарт, чанарын хяналтын горим шаардлагыг хангасан эсэхийг шалгах,

3.9.2. Ашиг алдагдлын дансдын аудитын хамрах хүрээ, горимуудын хэрэгжилтийг хүснэгт 5 (1-3)-аар бүрэн шалгаж тайлбар өгөх,

3.10. Орлогын аудитын чанарын хяналт

3.10.1. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны үр дүнд үүссэн борлуулалт үйлчилгээ, хөрөнгө оруулалт, хүү, ногдол ашиг, эрхийн төлбөр зэрэг орлогыг данс бүртгэлд үнэн зөв бүртгэгдсэн эсэх, стандарт, чанарын хяналтын горим шаардлагыг хангасан эсэхийг шалгах,

3.10.2. Орлогын аудитын хамрах хүрээ, горимуудын хэрэгжилтийг хүснэгт 5А (1-5)- аар бүрэн шалгаж тайлбар өгөх,

3.11. Зардлын аудитын чанарын хяналт

3.11.1. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны зардлыг зөв ангилж, данс бүртгэлд үнэн зөв бүртгэгдсэн эсэх, стандарт, чанарын хяналтын горим шаардлагыг хангасан эсэхийг шалгах,

3.11.2. Зардлын аудитын хамрах хүрээ, горимуудын хэрэгжилтийг хүснэгт 5Б (1-9)- өөр бүрэн шалгаж тайлбар өгөх,

3.12. Болзошгүй гэнэтийн өр төлбөр болон балансын дараах үйл явдлын аудитын чанарын хяналт

3.12.1. Бүрэн биелэгдээгүй гэрээнээс үүссэн нөөц, хэзээ ямар дүнгээр төлөх нь тодорхойгүй байгаа өр төлбөр, аж ахуйн нэгжийн өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн өнөөгийн үүрэг хариуцлага, тодорхой бус үйл явдлаас хамааран үүсэх нь тогтоогдох боломжтой хөрөнгө, бүтцийн өөрчлөлтийн үр дүнд үүсэж болзошгүй гэнэтийн өр төлбөрийг шинжилж, данс бүртгэлд үнэн зөв бүртгэгдсэн эсэх, стандарт, чанарын хяналтын горим шаардлагыг хангасан эсэхийг шалгах,

3.12.2. Аудитын компани нь болзошгүй гэнэтийн өр төлбөр болон балансын дараах үйл явдлын аудитын хамрах хүрээ, горимуудын хэрэгжилтийг хүснэгт 6 (1-4) - өөр бүрэн шалгаж тайлбар өгөх,

3.13. Харилцан хамаарал бүхий талуудтай хийсэн ажил гүйлгээний аудитын чанарын хяналт

3.13.1. Холбоотой талуудын ажил гүйлгээ нь орлогын тайлан, санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг шинжилж, бүртгэлд үнэн зөв тусгагдсан эсэхийг шалгах,

3.13.2. Аудитын компани нь харилцан хамаарал бүхий талуудтай хийсэн ажил гүйлгээний аудитын хамрах хүрээ, горимуудын хэрэгжилтийг хүснэгт 7(1-4) - өөр бүрэн шалгаж тайлбар өгөх,

Дөрөв. Аудитын чанарын хяналт шалгалтын тайланг бэлтгэж танилцуулах

4.1. Чанарын хяналт дууссанаас хойш ажлын 14 хоногт багтааж шалгалтын дүнг багийн ахлагч СТАҮЧХГ-ын даргад танилцуулна.

4.2. Чанарын хяналт шалгалтын тайланд дараах мэдээллийг тусгана.

4.2.1 Хяналт шалгалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүн, хамрагдсан хүрээ, хяналт шалгалт хийсэн хугацаа,

4.2.2. Хяналт шалгалтын тайланг журамд заасан бүтцийн дагуу холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, (АОУС), (ЧХОУС) , (СТОУС) -ын хэрэгжилтийн талаар товч тодорхой бичих,

4.2.3. Чанарын хяналтын горимын хэрэгжилтэнд өгсөн үнэлэлт дүгнэлт,

4.2.4. Шалгалтын явцад илэрсэн зөрчилийг газар дээр нь засаж залруулах арга хэмжээ авсан тухай,

4.2.5. Шалгалтын явцад санал гомдол хүлээн авсан бол түүнийг хэрхэн шийдвэрлэсэн тухай,

4.2.6. Өмнөх шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн талаар,

4.3. Шалгалтын тайланг аудитын компани тус бүрээр 2 хувь бичиж, гарын үсэг зурж, 1 хувийг компанид өгч, үлдэх хувийг хувийн хэрэгт хавсаргана.

4.4 Хяналт шалгалтын тайланг нэгтгэн, Хорооны удирдлагад танилцуулна.

Тав. Хариуцлага

5.1. Аудитын компани нь зохицуулалтын хүрээний байгууллагын санхүүгийн тайланд зохих хууль, журам, стандартын дагуу бүрэн гүйцэт аудит хийгээгүй нь тогтоогдвол холбогдох хууль тогтоомжинд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Аудитын компанийн мэдээлэл

Аудитын компанийн нэр:

Огноо:

Мэдээллийн төрөл	Үндсэн		Тайлбар */**
Аудитлагдсан компанийн мэдээлэл: /Тухай санхүүгийн жилийн байдлаар/			
Компанийн нэр:			
Үйл ажиллагааны чиглэл/ ангилал:			
Регистрийн дугаар:			
Улсын бүртгэлийн дугаар:			
Дүрмийн сангийн хэмжээ:			
Нийт хөрөнгийн хэмжээ:			
А аудитын компани, аудиторын шалгуур үзүүлэлт:			
Аудитын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүчинтэй эсэх болон бусад мэдээлэл:			
Тусгай зөвшөөрлийн дугаар:			
Сангийн сайдын тушаал / Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа:			
Үйл ажиллагаа эрхэлж буй хугацаа:			
Нэмэлт мэдээлэл:			
Аудит хийх эрхтэй аудитор, ажилтаны тоо	Үндсэн	Туслах	Гэрээт /Бусад ажилтан/
СХЗ-оос эрх авсан аудиторын нэрс: Овог, нэр	Үнэмлэхний дугаар /*Хүчинтэй хугацаа/	МНБГ, АБ-ын дугаар	Бусад мэдээлэл
1/			
2/			
3/			
4/			
5/			
Ажлын байр, программ хангамж, бичиг баримтын хадгалалт			
Хорооноос гаргасан журмын шаардлага, бусад нөхцлийг хангаж байгаа эсэх			
Аудит хийх ажлын гэрээ байгуулсан эсэх			

Гүйцэтгэсэн:

Шалгалтын ажлын хэсгийн ахлагч

Гишүүд:

Танилцаж зөвшөөрсөн :

Аудитын компанийн захирал

Аудитын гүйцэтгэлийн чанарын хяналт

Аудитын компанийн нэр:

Огноо:

1. Эргэлтийн хөрөнгийн аудит

№	Аудитын үзүүлэлт	Үнэлгээ 1-5 оноо	Тайлбар
А	Мөнгөн хөрөнгийн аудит		
1	Касс, харилцахыг валютын төрлөөр ангилж ,тайлант хугацааны эцсийн банкны хуулга, хадгаламжийн дэвтрийн үлдэгдлийг НББ-ийн үлдэгдэлтэй тулган шалгасан эсэх		
2	Бэлэн мөнгөний үлдэгдлийн тооллого , хадгалалт хамгаалалтыг шалгасан эсэх		
3	Салбарт явуулсан , салбараас татсан бэлэн мөнгөний үлдэгдлийг цаг хугацаанд нь нийлж тохируулсаныг шалгасан эсэх		
4	Харилцах дансыг банкуудад сонгож байршуулсаныг шалгасан талаар		
5	Ханшийн тестийн гүйцэтгэлийг шалгасан эсэх		
6	Мөнгөн гүйлгээний тайланг шалгасан эсэх		
7	Балансын өдрийн дараа банкаар хийгдсэн ажил гүйлгээ нь зохих тайлант хугацаандаа бүртгэгдсэн эсэхийг тодруулсан эсэх		
Б	Авлагын дансны аудит		
1	Авлагын үлдэгдэл , ангилал үнэн зөв эсэхийг шалгасан байдал		
2	Авлагын үлдэгдлийг тулган баталгаажуулж холбогдох горимуудыг гүйцэтгэсэн эсэх		
3	Үлдэгдлийг баталгаажуулах, харилцагчийг түүвэрлэн сонгохдоо ач холбогдол бүхий мөнгөн дунг нягтлан шалгасан эсэх		
4	Шалгасан үлдэгдэл ба бүртгэлээрх үлдэгдлийн зөрүүд шинжилгээ хийж баталгаажуулсан эсэх		
5	Авлагын насжилтын судалгаа, эргэцийн шинжилгээ хийх, авлага цуглуулах аудитын тусгай горимыг хэрэгжүүлсэн эсэх		
6	Зээлээрх борлуулалтын авлагыг бусдад шилжүүлэх, барьцаалах зэрэг ажил гүйлгээ нь зохистойг шалгаж баталгаажуулсан эсэх		
7	Хугацаа хэтэрсэн болон нэг жилээс дээш хугацаатай авлагын гэрээний нөхцөлд үнэлгээ дүгнэлт өгсөн эсэх		
8	Найдваргүй авлагын нөөцийн тооцооллыг шалгасан эсэх		
9	Данснаас хасагдсан авлагыг нотлох баримттай нь тулган шалгасан эсэх		
10	Авлагатай холбоотой бүртгэлийн бичилтүүдийг шалгасан эсэх		
В	Бараа материалын аудит		
1	Бараа материалаарх хөрөнгийн төрөл тус бүрээр тайлант хугацааны эцсийн үлдэгдлийн дэлгэрэнгүйг НББүртгэлтэй тулган шалгасан эсэх		

2	Биет тооллогын үлдэгдлийн үнэн зөв эсэхийг шалгаж тодруулсан эсэх		
3	Өртөг тооцох аргын зохистой байдлыг үнэлж шалгасан эсэх		
4	Нэгжийн өртгийн тооцооллын үнэн зөв эсэхийг шалгаж тодруулсан эсэх		
5	Өртгөөсөө бага цэвэр боломжит үнэтэй бараа материал, хуучирсан бараа материалын хувьд үнэлгээг цэвэр боломжит үнэ цэнэ рүү бууруулах шаардлагатай эсэхийг судалсан эсэх		
6	Бараа материал , бэлэн бүтээгдэхүүн ДҮ-ийн худалдан авалт, ачуулалт ба борлуулалтын тасалбар болголт үнэн зөв эсэхийг нягтлан шалгасан байдал		
7	Бараа материал ямар нэгэн зээл болон өр төлбөрт барьцаалагдсан эсэхийг нягтлан шалгасан байдал		
8	Дуусаагүй барилгын ажлын зардлыг үнэлсэн үнэлгээ үнэн зөв эсэхийг шалгасан байдал		
Г	Хөрөнгө оруулалтын дансны аудит		
1	Хөрөнгө оруулалтын ангилал тус бүрээр тайлант хугацааны эцсийн үлдэгдлийн дэлгэрэнгүйг шинжилж, НББүртгэлтэй тулган шалгасан эсэх		
2	Хадгалж байгаа , барьцаанд байгаа үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын үлдэгдлийг нягталж шалгасан эсэх		
3	Биет шалгалт болон үлдэгдэл шалгасны үр дүнг бүртгэлээрх үлдэгдэлтэй тулган холбогдох зөрүүд шинжилгээ хийсэн эсэх		
4	Хөрөнгө оруулалтын үр ашгийг үнэлж дүгнэсэн эсэх		
5	Дансны өөрчлөлтүүдийн дэлгэрэнгүйг авч анхаарал татсан өөрчлөлтийн хувьд ажил гүйлгээ явагдсан огноо, дүн, борлуулалтын алдагдал зэргийг шалгаж тодруулсан эсэх		
6	Өөрчлөлт бүхий ажил гүйлгээг шалгахдаа түүвэрлэлтийг зөв зохистой хийсэн эсэх		
7	Үнэлгээний аргын зохистой эсэхийг шалгаж тодруулсан эсэх		
8	Балансын өдрийн байдлаарх зах зээлийн үнэ эсвэл бодит үнийн дүнг зохих ёсоор шалгасан эсэх		
9	Хөрөнгө оруулалтын үнэлгээний бууралт зохистойгоор хийгдсэнийг шалгаж тодруулсан эсэх		

2. Эргэлтийн бус хөрөнгийн аудит

№	Аудитын үзүүлэлт	Үнэлгээ 1-5 оноо	Тайлбар
Үндсэн хөрөнгийн аудит			
1	Тайлант хугацааны эхний ба эцсийн үлдэгдэл тухайн тайлант хугацааны өөрчлөлтийг тусгасан тайланг авч шинжилсэн эсэх		
2	Тайлант хугацааны эцсийн үлдэгдлийн дэлгэрэнгүйг НББүртгэлтэй тулган шалгасан эсэх		

3	Онцгой өсөлттэй гарсан ажил гүйлгээний хувьд үндсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн нь зөв эсэх , худалдан авсан үнэ үндсэн хөрөнгийн ангилал нь зөв зохистой эсэхийг шалгаж тодруулсан эсэх		
4	Шинээр худалдан авсан хөрөнгийн ашиглалтын хугацаа нь зохистой тогтоогдсон эсэх		
5	Элэгдлийн зардал хуримтлагдсан элэгдлийн дүн нь үнэн зөв эсэх		
6	Ашиглагдаагүй хөрөнгө, устгах шаардлагатай хөрөнгө, хүлээгдэж буй дуусаагүй барилгын түр данс бий эсэх , бүртгэл хөтлөлтийн үнэн зөв эсэхийг шалгаж тодруулсан эсэх		
7	Түрээсийн гэрээтэй танилцаж шалгаж тодруулсан эсэх		
8	Хөрөнгөнд барьцаа дэнчин авсан байдлыг шалгаж тодруулсан эсэх		
9	Үндсэн хөрөнгийн гарзыг бүртгэлд үнэн зөв тусгасан эсэхийг шалгасан байдал		
10	Биет бус хөрөнгийг үнэн зөв бүртгэсэн эсэх		

3. Өр төлбөрийн аудит

№	Аудитын үзүүлэлт	Үнэлгээ 1-5 оноо	Тайлбар
A	Урт болон богино хугацаат өр төлбөрийн аудит		
1	Тайлант хугацааны эцсийн урт болон богино хугацааны өр төлбөрийн дэлгэрэнгүйг авч шинжилсэн эсэх		
2	Тайлант хугацааны эцсийн үлдэгдлийн дэлгэрэнгүйг бүртгэлтэй тулгасан эсэх		
3	Зээлийн үлдэгдлийг нягталж шалгасан эсэх		
4	Зээлийн үлдэгдлийг шалгасан дүн болон бүртгэлийн үлдэгдлийн хоорондын зөрүүд шинжилгээ хийсэн эсэх		
5	Их дүнгээр өссөн ажил гүйлгээний хувьд орсон мөнгөн гүйлгээг гэрээтэй нь тулган шалгасан эсэх		
6	Их дүнгээр буурсан ажил гүйлгээний хувьд гарсан мөнгөний гүйлгээг шалгасан эсэх		
7	Хүүгийн төлбөр нь зээлийн үлдэгдэлтэй тохирч буй эсэхийг нягтлан шалгасан эсэх		
8	Урт ба богино хугацааны өр төлбөрийн ангилал үнэн зөв эсэхийг шалгасан байдал		
9	Барьцаат зээлтэй холбоотой асуудлуудыг нягтлан шалгасан эсэх		
10	Эрсдлийн болон нөөц сангуудын тооцоолол, нөөц санд төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ, зарцуулалтыг шалгасан эсэх		
11	Зальт ажиллагаатай холбоотой горимыг гүйцэтгэсэн эсэх		
B	Татварын өр, хойшлогдсон татварын хөрөнгийн аудит		
1	Тайлант хугацааны эцэст татварын өр төлбөрийг шинжилсэн эсэх		
2	Аж ахуйн нэгжийн татварын тайланг бүртгэлтэй тулган шалгасан эсэх		
3	Компанийн бүх төрлийн татварын тооцооллын үнэн зөвийг нягтлан шалгасан эсэх		

4	Бүртгэлийн стандартаар хүлээн зөвшөөрөгддөг боловч татварын хуулиар хүлээн зөвшөөрөгддөггүй орлого, зардлуудыг үнэн зөв тодорхойлж бүртгэсэн эсэх		
5	Бүртгэлийн стандартаар хүлээн зөвшөөрөгддөггүй боловч, татварын хуулиар хүлээн зөвшөөрөгддөг орлого, зардлуудыг үнэн зөв тодорхойлж бүртгэсэн эсэх		
6	Татварын холбоотой анхаарал татсан гүйлгээнүүд , буцаалт засвар өөрчлөлтүүд нь НББүртгэлд үнэн зөв тусгагдсан эсэх, нэмэлт тодруулга хийгдсэн эсэх		
7	Тайлант хугацааны эцэст хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн үлдэгдлийг шинжилсэн эсэх		
8	Хойшлогдсон татварын хөрөнгө ,өр төлбөрийн дүнг үнэн зөв тооцоолсон эсэхийг шалгах		
9	Татварын өмнөх ашигт ногдох татварын зардал ба хуулиар тогтоосон бодит татварын зардлын хоорондын зөрүүгийн шалтгааныг тодорхойлсон эсэх		

4. Эзэмшигчийн өмчийн аудит

№	Аудитын үзүүлэлт	Үнэлгээ 1-5 оноо	Тайлбар
Эзэмшигчийн өмчийн аудит			
1	Тайлант хугацааны эцсийн эзэмшигчийн өмчийн дансдын үлдэгдлийг шинжилсэн эсэх		
2	Өөрийн хөрөнгийг бүртгэлд бодитой тусгасан эсэх /Дүрмийн сан,Ашиг алдагдал,дахин үнэлгээний зөрүү,бусад хэсэг/		
3	Өмчийн дансдын дүнд өөрчлөлт оруулсан ажил гүйлгээ гарсан бол захирлуудын зөвлөлийн хурлын протокол зэрэг нотлох баримтуудыг тулган шалгасан эсэх		
4	Эзэмшигчийн өмчийн өсөлт, шинээр хөрөнгө оруулалт хийх , өөрчлөлт гарсан зэрэг ажил гүйлгээтэй холбоотой НББ хөтлөлтийг шалгасан эсэх		
5	Ногдол ашгийн бодлого өөрийн хөрөнгийн удирдлагатай нийцэж байгаа эсэх		
6	Ногдол ашиг зөв зохистой дүнгээр төлөгдсөн эсэхийг шалгах		

5. Ашиг алдагдлын дансдын аудит

№	Аудитын үзүүлэлт	Үнэлгээ 1-5 оноо	Тайлбар
1	Шинжилгээ хийх замаар ашиг алдагдлын дансууд үнэн зөв бүртгэгдсэнийг шалгасан эсэх		
2	Ашиг алдагдлыг тайлант хугацааны эцсийн байдлаарх дэлгэрэнгүй бүртгэлтэй тулган шалгасан эсэх		
3	Хуримтлагдсан ашгийн дансанд нөлөөлөх ажил гүйлгээг шинжилсэн эсэх		

А Орлогын аудит		
1	Борлуулалтын орлогыг үнэн зөв иж бүрнээр бүртгэлд тусгасан эсэхийг шалгах	
2	Орлогын гүйлгээний баримтууд ба НББ-ийн бичилтүүдийг шалгасан эсэх	
3	Орлого үр дүнгийн тайланд үнэн зөв бүрэн ангилан тайлагнасан эсэхийг нягтлан шалгах	
4	Том ба ердийн орлогуудын хувьд нарийвчилсан горим гүйцэтгэсэн эсэх	
5	Борлуулалтын ажил гүйлгээнд тасалбар болголтын тест гүйцэтгэсэн эсэх	
Б Зардлын аудит		
1	Зардлын гүйлгээний баримтууд ба НББ-ийн бичилтүүдийг шалгасан эсэх	
2	Зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлд шинжилгээ хийж дүгнэлт өгсөн эсэх	
3	Зардлын ангилал, өсөлт бууралт өөрчлөлтийг шалгаж дүгнэлт өгсөн эсэх	
4	Орлого үр дүнгийн тайланд үнэн зөв бүрэн ангилан тайлагнасан эсэхийг нягтлан шалгах	
5	Худалдан авалтыг үнэн зөв, иж бүрэн бүртгэлд тусгасан эсэхийг шалгах	
6	Худалдан авалтын ажил гүйлгээнд тасалбар болголтын тестийг гүйцэтгэсэн эсэх	
7	Төлбөрийн чадварын үзүүлэлтүүдийг шинжлэн үнэн зөв эсэхийг шалган дүгнэлт өгсөн эсэх	
8	Шинжилгээ хийх замаар борлуулалтын өртөг үнэн зөв тодорхойлогдсоныг шалгасан эсэх	
9	Хүүгийн , ногдол ашгийн , хөрөнгө оруулалтын орлогын дүнгүүд нь холбогдох балансын үзүүлэлтүүдтэй тохирч байгааг шалгасан эсэх	

6. Болзошгүй гэнэтийн өр төлбөр болон балансын дараахь үйл явдлын аудит

№	Аудитын үзүүлэлт	Үнэлгээ 1-5 оноо	Тайлбар
1	Банк санхүүгийн байгууллагаас ирүүлсэн үлдэгдэл шалгах баримтанд болзошгүй гэнэтийн өр төлбөр үүсч болохыг сануулсан тэмдэглэл байгаа эсэхийг шалгаж тодруулсан эсэх		
2	Шүүхэд гаргасан нэхэмжлэлийн хамрах хүрээ, бодитой эсэхийг шалгаж тодруулсан эсэх Одоо шүүх дээр маргаантай байгаа хэрэг Маргаантай эсэх нь тодорхой бус хэрэг Хохирлын нөхөн төлбөр Ойрын хугацаанд нэхэмжлэл гаргаж болзошгүй нөхцөл байдал		
3	Шүүхэд гаргасан нэхэмжлэлийн эрсдлийг хянах тогтолцооны талаарх аудитын үнэлгээ		
4	Балансын дараахь үйл явдлын талаар шалгаж тодруулсан эсэх		

7. Харилцан хамаарал бүхий талуудтай хийсэн ажил гүйлгээний аудит

№	Аудитын үзүүлэлт	Үнэлгээ 1-5 оноо	Тайлбар
1	Харилцан хамаарал бүхий талуудтай холбоотой эрсдлийг үнэлэн зохих горимуудыг тодорхойлсон эсэх		
2	Харилцан хамаарал бүхий талуудын хамрах хүрээ, ажил гүйлгээний төрөл, ач холбогдлыг үнэлэх		
3	Мөнгөн дүн үнэн зөв эсэхийг үнэлэх		
4	Харилцан хамаарал бүхий компани, ажилтнууд, томоохон хувьцаа эзэмшигчидтэй холбоотой гүйлгээ хуулийн дагуу бүртгэгдсэнийг шалгасан эсэх		

Гүйцэтгэсэн:

Шалгалтын ажлын хэсгийн ахлагч

Гишүүд:

Танилцаж зөвшөөрсөн :

Аудитын компанийн захирал

Чанарын хяналтын мэргэжилтэн

Багийн ахлагч аудитор

Аудитор

Аудиторын туслах

АОУСтандартын хэрэгжилт

Байгууллагын нэр:

Огноо:

№	АОУС	Үзүүлэлт	Үнэлгээ 1-5 оноо	Тайлбар	
1	210. Аудитын ажлын нөхцлүүд	Захидал хэлбэрээр			
2		Гэрээний хэлбэрээр			
3		Давтагдаж буй аудитын үед аудитын ажлын нөхцлүүд шинэчлэх шаардлага гарсан			
4	220. Санхүүгийн түүхэн мэдээллийн аудитын чанарын хяналт	Ажлын баг аливаа аудитын гэрээт ажилд тохирох чанарын хяналтын горимуудыг хэрэгжүүлдэг			
5		Аудитын ажлыг хүлээн авах буюу үргэлжлүүлэх эсэхийг шийдэхдээ үйлчлүүлэгчийн удирдлагын шударга байдал, ажлын багийн мэдлэг чадвар туршлага боломж, өмнөх аудитын явцад үүссэн асуудлын үр нөлөө, учир шалтгааныг тус тус харгалзан үздэг			
6		Өөрт оногдсон аудитын гэрээт ажил тус бүрийн хувьд чанарын хариуцлагыг бүрэн хүлээдэг			
7		Багийн гишүүд ёс зүйн шаардлагыг хангаж ажилласан эсэхийг шалгадаг			
8		Мэргэжлийн ёс зүйн холбоотой бүх асуудлыг баримтжуулдаг			
9		Хараат бус байдлын талаарх дүгнэлт санал, бусад холбогдох хэлэлцүүлгийг баримтжуулдаг			
10		Ажлын багийг томилсон тушаал шийдвэр баримт			
11		Аудитор хийсэн санал дүгнэлтээ дэмжих нотлох зүйл нь хангалттай			
12		Гэрээт ажлын явцад ажлын багийн гишүүн ажлын баг дотроо зөвлөлддөг			
13		Санал бодлын зөрүү үүсвэл ажлын баг нь шийдвэрлэж чаддаг			
14		Аудитын ажлын чанарын хяналтын шалгагчийг томилдог			
15		Аудитын ажлын чанарын хяналт шалгалтын дуусаагүй байхад аудиторын тайланг гаргадаг			
16		Аудитын төлөвлөж гүйцэтгэх явцыг баримтжуулдаг			
17		Аудитын ажлыг хянан удирдах, давтан шалгахад баримтжуулдаг			
18		Аудитын ажлын багийн гишүүдийн хүлээх хариуцлагыг тодорхой болгоход ажлын баримт хамрагддаг			
19			Дараагийн аудитад ач холбогдолтой зүйлсийг авч үлдэхэд ажлын баримт шаардлагатай		

20		Чанарын хяналтын хэрэгжүүлэх боломж нөхцлийг бүрдүүлэхэд ажлын баримтыг ашигладаг		
21	230. Аудитын баримтжуулалт	Дотоод хяналтыг хэрэгжүүлэх боломж нөхцлийг хангах зорилгоор ажлыг баримтжуулдаг		
22		Аудитын явцад илэрсэн онцлог зүйлсийн тодорхойлох шинж чанарыг баримтжуулдаг		
23		Аудитор чухал асуудлын тухайд үйлчлүүлэгчийн удирдлагатай уулзаж ярилцах бүрдээ баримтжуулалт хийдэг		
24		Аудитор чухал асуудлын хувьд дүгнэлтэйгээ зөрчилдсөн мэдээллийг олж тогтоосон бол энэ талаар баримтжуулдаг		
25		Ажлын баримтыг бэлтгэгчтэй		
26		Ажлын баримтыг шалгагчтай		
27		Аудитын ажлыг хэн, хэзээ гүйцэтгэснийг баримтжуулдаг		
28		Гүйцэтгэсэн аудитыг хэн, хэзээ ямар цар хүрээнд шалгасныг тайлагнахад баримтжуулдаг		
29		Аудитор нь аудиторын дүгнэлт гарсны дараа аудитын төгсгөлийн файлыг бүрдүүлж бэлэн болгодог		
30		Аудитын төгсгөлийн файлыг бэлэн болгосноос хойш түүнийг хадгалах хугацааг дуусах хүртэл ямар нэг баримтыг арилгаж, орхиглуулах үйл ажиллагаа явагддаг		
31		Аудитын төгсгөлийн файлыг бэлэн болгосноос хойш нэмэлт материал оруулахаар болбол, - Хэзээ, хэн үүнийг хийсэн, - Нэмэлт материал оруулах болсон шалтгаан, - Түүний аудиторын дүгнэлтэд үзүүлэх нөлөө зэргийг дурьддаг		
32		Аудиторын дүгнэлт гарснаас хойш зарим онцгой тохиолдолд нэмэлт болон шинэ аудитын горим гүйцэтгэж ажлын баримтад өөрчлөлт оруулахаар бол, - Тухайн нөхцөл байдлын тухай, - Гүйцэтгэсэн нэмэлт болон шинэ аудитын горим, олж авсан нотлох зүйлс, - Эдгээрээс үүдэн хэн, хэзээ ажлын баримтад өөрчлөлт оруулсан зэргийг дурьддаг		
33		Залилангаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг тодруулахад ашигладаг мэдээллийг олж авахуйц горимуудыг гүйцэтгэдэг		
34		Залилангаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг санхүүгийн тайлангийн түвшинд тодруулж үнэлдэг		

35	240. Санхүүгийн тайлангийн аудитад залиланг авч үзэх аудиторын үүрэг	Залилангийн улмаас материаллаг буруу илэрхийлэлд хүргэж болох үнэлэгдсэн эрсдэлийн хувьд байгууллагын холбогдох хяналт, үүнд хяналтад хамааралтай үйл ажиллагааны загварыг үнэлэх, мөн эдгээрийг хэрэгжүүлсэн эсэхийг тодорхойлдог		
36	хариуцлага	Аудитын горимуудыг төлөвлөж гүйцэтгэх ба түүний үр дүнг үнэлж тайлагнах үедээ аудитор залилангийн улмаас санхүүгийн тайланд материаллаг буруу илэрхийлэл байх эрсдлийг авч үзсэн		
37		Хэрэв залилан эсвэл залилан байж болох сэжигээс үүссэн материаллаг буруу илэрхийллийн үр дүнд уг аудитыг үргэлжлүүлэн гүйцэтгэх аудиторын боломжит асуудал тулгарвал хэрхэх тухай удирдамжаар хангах		

Гүйцэтгэсэн:

Шалгалтын ажлын хэсгийн ахлагч

Гишүүд:

Танилцаж зөвшөөрсөн:

Аудитын компанийн захирал

Чанарын хяналтын мэргэжилтэн

Багийн ахлагч аудитор

Аудитор

Аудиторын туслах

-----oOo-----